МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/156 Мөрөн сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2, 16 дугаар зүйл 16.2.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.3, 16 дугаар зүйлийн 16.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мөрөн бетон" ХХК-ийн Мөрөн сумын нутагт орших "Их элстэй" нэртэй Х/00010 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хоёр жилийн хугацаатай сунгасугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг "Мөрөн бетон" ХХК (Х.Батбаяр)-д даалгасугай.

3. "Мөрөн бетон" ХХК-ийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Мөрөн сумын Засаг дарга (Б.Батбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 12 ний өдрийн
А/ 156 дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН
ТАЛБАЙН СОЛБИЦОЛ

Цэгийн дугаар	X	У
1	2	3
1	100° 12' 57.46"	49° 36' 10.88"
2	100° 12' 57.46"	49° 35' 33.43"
3	100° 12' 35.37"	49° 35' 33.43"
4	100° 12' 35.37"	49° 36' 10.88"

_____oOo_____